

(А-ДБ-9) Шинэ элсэгч, мэргэжлийн чиглэлээр

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИЙН КОД	ТАЙЛАНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангиллаар	3-ДБ-34	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, аймаг, нийслэл, дүүргээр

Заавар: (А-ДБ-9) МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

А. Үндсэн мэдээлэл Нийт шинээр элсэгчид (багана 1:3) -Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн нийт тоог (багана 1)-т, дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элссэн эрэгтэйчүүдийн тоог (багана 2)-т, эмэгтэй элсэгчдийн тоог (багана 3)-т тус тус бичнэ багана1=(2+3)=(4+7+10+13). Дипломын боловсрол (багана 4:6) -Дипломын боловсролд шинээр элсэгчдийн нийт тоог (багана 4)-т, эрэгтэй элсэгчдийн тоог (багана 5)-д, эмэгтэй элсэгчдийн тоог (багана 6)-д тус тус бичнэ багана4=(5+6). Бакалаврын боловсрол (багана 7:9) -Бакалаврын боловсролд шинээр элсэгчдийн нийт тоог (багана 7)-д, эрэгтэй элсэгчдийн тоог (багана 8)-д, эмэгтэй элсэгчдийн тоог (багана 9)-д тус тус бичнэ багана7=(8+9). Магистрын боловсрол (багана 10:12) -Магистрын боловсролд шинээр элсэгчдийн нийт тоог (багана 10)-т, эрэгтэй элсэгчдийн тоог (багана 11)-т, эмэгтэй элсэгчдийн тоог (багана 12)-т тус тус бичнэ багана10=(11+12). Докторын боловсрол (багана 13:15) -Докторын боловсролд шинээр элсэгчдийн нийт тоог (багана 13)-т, эрэгтэй элсэгчдийн тоог (багана 14)-т, эмэгтэй элсэгчдийн тоог (багана 15)-д тус тус бичнэ багана13=(14+15). Бүгд (мөр 1) -Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн улсын хэмжээний нийт дүнг бичнэ. Үүнээс задалж (мөр 2:26) -Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийг суралцаж буй мэргэжлийн ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэлээр ангилан бичнэ. Мэргэжлийн чиглэлийн ангиллыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78, 2014 оны А/370, 2015 оны А/138, 2015 оны А/262, 2017 оны А/52, 2019 оны А/336 дугаар тушаалын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх диплом, бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс”, ЮНЕСКО-гоос 2013 онд гаргасан “Боловсролын мэргэжлийн чиглэл-ISCED-F”-ийг баримтална. Боловсролын мэргэжлийн чиглэл нь 3 үе шаттай, дээрээс доош буюу ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл гэсэн тогтолцоотой, 4 оронтой тоогоор кодлогдсон байна. 10 ерөнхий чиглэл, 29 төрөлжсөн мэргэжил, 80 орчим нарийвчилсан мэргэжлээр хуваагдсан байна.

Түвшин Чиглэлийн ангилал Чиглэлийн тоо 1-р түвшин Ерөнхий чиглэл 10 2-р түвшин Төрөлжсөн мэргэжил 29 3-р түвшин Нарийвчилсан мэргэжил ≈ 80

Орц: “Суралцагч” модуль Суралцагчийн элсэлт, шилжилт хөдөлгөөн, үндсэн мэдээлэл, сургалтын мэдээлэл, статистик мэдээллийг оруулсны дараа системээр тодорхой дүрмээр бодолт хийж гарна. Модуль: Суралцагч Асуулгын маягт:ДБСБ-ын суралцагчийн асуулгын маягт- АМ-4

Асуулгын маягтын заавар: (АМ-4) СУРАЛЦАГЧИЙН АСУУЛГЫН МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Б. Үндсэн мэдээлэл Дээд боловсролын сургалтын байгууллагад тайлант хугацаанд бүртгэлтэй суралцагчийн мэдээллийг оруулна.

1. Ерөнхий мэдээлэл
2. Иргэншил – Суралцагчийн албан ёсны бүртгэлтэй харьяалагдах улсыг сонгоно.

3. Регистрийн дугаар/Бүртгэлийн дугаар - МУ-ын иргэн бол суралцагчийн Монгол улсын иргэний бүртгэлд бүртгүүлсэн регистрийн дугаар, гадаад хүн бол гадаад паспортын дугаарыг бичнэ.
4. Эцэг эхийн нэр - МУ-ын иргэн бол суралцагчийн Монгол улсын иргэний бүртгэлд бүртгүүлсэн Эцэг/Эхийн нэр, гадаад хүн бол гадаад паспорт дээрх Эцэг/Эхийн нэрийг латин үсгээр бичнэ.
5. Нэр - МУ-ын иргэн бол суралцагчийн Монгол улсын иргэний бүртгэлд бүртгүүлсэ